ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





ГАРЧИГ

БИД ХЭН БЭ ? 2

ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ 4

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ КАМПАНИТ АЖИЛ 6

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ КАМПАНИТ АЖИЛ 7

ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮМҮҮС КАМПАНИТ АЖИЛ 8

ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ КАМПАНИТ АЖИЛ 10

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ КАМПАНИТ АЖИЛ 12

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛ 14

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

БИД ХЭН БЭ

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн төлөөх хүмүүсийн дэлхий дахины хөдөлгөөн юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид.

Манай **ЭРХЭМ** зорилго Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрхийг энэ дэлхийн хүн бүрт эдлүүлэхэд оршино.

Эмнести Интернэшнл 150 гаруй улс орон, газар нутагт 7 сая гишүүд дэмжигчидтэй. **Монголын Эмнести Интернэшнл** мэргэжил, сонирхолоороо нэгдсэн 6000 гаруй гишүүд, дэмжигчидтэй

УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Б.Болорсайхан
Удирдах зөвлөлийн дарга



А.Түвшинтулга
Удирдах зөвлөлийн дэд дарга



С.Ганчимэг
санхүү хариуцсан гишүүн



А.Отгончимэг
ХЭБ хариуцсан гишүүн



Б.Энхтуяа
Кампанит ажил хариуцсан гишүүн



М.Батбаатар
Кампанит ажил хариуцсан гишүүн



З.Балдорж
Гишүүнчлэл хариуцсан гишүүн



С.Урангоо
Залуучууд хариуцсан гишүүн



Т.Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Б.Мөнхжавхлан
Хяналтын зөвлөлийн дарга



С.Очирбат
Хяналтын зөвлөлийн гишүүн



М.Отгонгэрэл
Хяналтын зөвлөлийн гишүүн

ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирал



Г.Амарзаяа
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



П.Мөнхжаргал
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



Т.Ариунаа
Санхүүгийн ажилтан



Б.Энхбаяр
Залуучууд, цахим хэвлэл мэдээлэл хариуцсан зохицуулагч



П.Цэндсүрэн
Гишүүнчлэл, харилцаа хариуцсан зохицуулагч

САЙН ДУРЫНХАН

Сайн дурынхан нь хүний эрхийг хамгаалах, түгээх, хүний эрхийн боловсрол олгох их үйлсэд сургалт сурталчилгаа, кампанит ажил зохион байгуулах, орчуулга хийх, мэдээлэл түгээх, тараах материал бэлтгэх, гишүүд дэмжигчидтэй харилцах зэргээр мэдлэг,боломж, цагаа үнэ төлбөргүйгээр зориулдаг гишүүд, дэмжигч, хүний эрхийн идэвхтнүүд юм.



2017 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад 167 сайн д ажилтан 4220 цагаа хандивлав. МУИС, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн 8 оюутан мэргэжлийн дадлага хийв.

ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛДЭГ ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙН ТӨЛӨӨ

Эмнести Интернэшнлийн 2016-2019 оны хооронд нэн тэргүүнд анхаарч ажиллах Хүний эрхийн стратеги зорилт

1 Хүн бүр эрхээ мэддэг, эрхээ хэрэгжүүлж чаддаг дэлхий ертөнц

- Хүн бүр үг хэлэх, эрхийнхээ төлөө эвлэлдэн нэгдэх, хуран чуулах, шударга бус явдлыг таслан зогсоохын төлөө эрхээ шаарддаг болох
- Хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал хангагдаж, тэдэнд дэмжлэг үзүүлдэг байх
- Хүмүүсийг эрхээ мэддэг, шаарддаг болж чадавхижуулах

2 Хүн бүр хүний эрх, шударга ёсыг тэгш эдэлдэг дэлхий ертөнц

- Хүйсийн тэгш байдлыг бий болгоход ахиц гарах
- Олон талт алагчлалын хохирогчдын хувьд алагчлал, онцлогт суурилсан хүчирхийлэл буурах
- Хүмүүсийн амьдралд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг илүү хэрэгжүүлэх

3 Хямрал, зэвсэгт мөргөлдөөний үеэр энгийн иргэдийг хамгаалж чаддаг дэлхий ертөнцийн төлөө

- Хүний эрхийг зөрчигчдөд хариуцлага тооцдог, хохирогчид нь шударга ёс, үнэн мөнөө олж, хохирлоо төлүүлж чаддаг болох
- Зэвсэгт мөргөлдөөн, хямрал, эрүү шүүлт, мөрдлөг хавчлагад өртсөн хүмүүс хангалттай хамгаалалт, дэмжлэг туслалцаа авч чаддаг болох
- Үндэсний, бүс нутгийн болон олон улсын институт, механизмуудын үр дүнтэй үйл ажиллагааны үр дүнд энгийн иргэд илүү сайн хамгаалагддаг болох

4 Хүний эрхийн зөрчил үйлдэгчдэд хариуцлага тооцдог дэлхий ертөнц

- Стратегийн 1-3-р зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүний эрхийн засаглал, хариуцлагыг үндэсний түвшинд бэхжүүлэх
- Хүний эрхийн хамгаалалт сул газарт бүсийн ба олон улсын хүний эрхийн механизмыг бэхжүүлэх

5 Эмнести Интернэшнл илүү том, үр дүнтэй, эрч хүчтэй байгууллага болно

- БИД Эмнести Интернэшнлийг хүний эрхийн илүү их үр нөлөөнд хүргэхийн тулд өөрсдийн нөөц бололцоо, үйл ажиллагааг хамгийн дээд түвшинд хүргэх
- Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааны бүх түвшинд олон талт байдлыг хангасан идэвхитэй оролцоог өргөжүүлэх

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ КАМПАНИТ АЖИЛ



ТА ТЭМЦСНИЙ ҮР ДҮНД МОНГОЛ УЛСАД ЦААЗААР АВАХ ЯЛ ТҮҮХ БОЛЖ ҮЛДЛЭЭ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12-р сарын 3-нд баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад цаазаар авах ялыг халсан ба энэ хууль 2017 оны 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэллээ.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд, ХЭҮК-той хамтран Хууль зүй дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, УИХ зэрэг хууль тогтоогчид, төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандсан бидний нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд Монгол улс цаазаар авах ялыг халсан дэлхийн 105 дахь улс болов. НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгийн үеэр Монгол улсаас Өмнөд Солонгос, Япон улс хандан цаазаар авах ялаа халахыг зөвлөмж өглөө.

ТА ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХИЙН ЭСРЭГ ДУУ ХООЛОЙГОО ӨРГӨСӨН.



2017 оны 10-р сарын 16-нд Монгол улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялыг сэргээх санал гаргасанд харамсаж байгаагаа илэрхийлэн Эмнести Интернэшнлийн цаазаар авах ялын эсрэг байр суурь, бусад мэдээ мэдээллийг өдөр тутмын сонин, телевиз, вэб сайт, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэв.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НӨЛӨӨЛӨЛ



Эмнести Интернэшнлийн Ерөнхий Нарийн бичгийн дарга Салил Шетти Монгол улсын Ерөнхийлөгч цаазаар авах ялыг сэргээх тухай санал Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэнд санаа зовниж буйгаа илэрхийлсэн нээлттэй захидал хүргүүллээ.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

БИД ХЭН БЭ

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн төлөөх хүмүүсийн дэлхий дахины хөдөлгөөн юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид.

Манай **ЭРХЭМ** зорилго Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрхийг энэ дэлхийн хүн бүрт эдлүүлэхэд оршино.

Эмнести Интернэшнл 150 гаруй улс орон, газар нутагт 7 сая гишүүд дэмжигчидтэй. **Монголын Эмнести Интернэшнл** мэргэжил, сонирхолоороо нэгдсэн 6000 гаруй гишүүд, дэмжигчидтэй

УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Б.Болорсайхан
Удирдах зөвлөлийн дарга



А.Түвшинтулга
Удирдах зөвлөлийн дэд дарга



С.Ганчимэг
санхүү хариуцсан гишүүн



А.Отгончимэг
ХЭБ хариуцсан гишүүн



Б.Энхтуяа
Кампанит ажил хариуцсан гишүүн



М.Батбаатар
Кампанит ажил хариуцсан гишүүн



З.Балдорж
Гишүүнчлэл хариуцсан гишүүн



С.Урангоо
Залуучууд хариуцсан гишүүн



Т.Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Б.Мөнхжавхлан
Хяналтын зөвлөлийн дарга



С.Очирбат
Хяналтын зөвлөлийн гишүүн



М.Отгонгэрэл
Хяналтын зөвлөлийн гишүүн

ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ТА ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХЫН ТӨЛӨӨ БИДЭНТЭЙ НЭГДСЭН





3 БА 10 ДУГААР САРД ЦААЗААР АВАХ ЯЛ БА ГҮЙЦЭТГЭЛ ТАЙЛАНГИЙН НЭЭЛТ, ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ, МУИС-ТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ЛЕКЦ, КИНО ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ 300 ГАРУЙ ИРГЭД, ОЮУТАН ЗАЛУУС ХАМРАГДАЖ ЦААЗААР АВАХ ЯЛ ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ ҮР НӨЛӨӨГҮЙ БӨГӨӨД ХИЛСЭЭР ЦААЗЛАХ, АРЬС ӨНГӨ, ШАШИН, ҮНДЭСТНЭЭР НЬ ЯЛГАВАРЛАН, УЛС ТӨРИЙН ЗОРИЛГООР ХЭРЭГЛЭХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ БОЛОХ ТУХАЙ ЯРИЛЦЛАА.

ТА ДЭЛХИЙН ДАХИНАА ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛСЭД ОРОЛЦСОН.



ФИЛИППИНИЙ ЭРХ БАРИГЧДААС ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ НЭРИЙН ДОР АЛЛАГА ҮЙЛДЭХЭЭ ЗОГСООХЫГ ШААРДСАН АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ЯАРАЛТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ОЮУТНЫ БҮЛГИЙН ГИШҮҮД НЭГДЛЭЭ.

ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ АЗИЙН СҮЛЖЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦОЖ, БҮС НУТАГ ДАХЬ ЦААЗААР АВАХ ЯЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ДЭЛХИЙ ДАЯАРАА ЦААЗААР АВАХ ЯЛААС ТАТГАЛЗАЖ БАЙНА



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛЭЭС 4-Р САРЫН 11-НД ДЭЛХИЙ ДАХИНАА ЦААЗААР АВАХ ЯЛ БА ГҮЙЦЭТГЭЛ 2016 СУДАЛГААНЫ ТАЙЛАНГ ДӨРВӨН ТЕЛЕВИЗ, ХОЁР ӨДӨР ТУТМЫН СОНИН, 11 ВЭБ САЙТ, ФЭЭСБҮҮКЭЭР ДООД ТАЛ НЬ 50 000 ХҮНД ХҮРГЭЛЭЭ.

ТАЙЛАНД ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД ДЭЛХИЙ ДАЯАР ЦААЗААР АВАХ ЯЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙДАЛ 37%-ИАР БУУРСАН БА ЭНЭ ЯЛЫГ ХУУЛЬДАА БОЛОН ПРАКТИКТ ХАЛСАН УЛС ОРНЫ ТОО 141 БОЛЖ, НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССЕМБЛЕЙГГАС БАТАЛСАН ЦААЗААР АВАХ ЯЛЫН ХЭРЭГЛЭЭНД МОРАТОРИ ТОГТООХ ТУХАЙ 6 ДАХЬ ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ МОНГОЛ, АРГЕНТИН УЛС ТЭРГҮҮЛЭН 89 УЛС САНААЧИЛАН БАТЛУУЛСНЫГ ДУРДСАН БАЙНА.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ КАМПАНИТ АЖИЛ


ТА
ЗОРИГТОН
ЗОРИГТОН
ЗОРИГТОН

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ КАМПАНИТ АЖИЛ

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ ЭМЧ НАР

Эрүүл мэндийн салбарын эмч ажилтнуудад эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн асуудлаар сургалт явуулж, ТББ-уудад эрүүдэн шүүхээс ангид байх эрхээ хамгаалах тухай уулзалт, ярилцлага хийв.



ЦАХИМ ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ЛЕКЦ

Хүний эрхийн идэвхтэн, тэмцэгч нарт цахим орчинд аюулгүй ажиллах, цахим халдлагаас хамгаалах тухай мэдээлэл өгөх лекц зохион байгууллаа.



ТЕХНОЛОГИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭХЭД АШИГЛАХ НЬ

Хүний эрх ба технологи сэдвийн хүрээнд Шихихутуг, ХСИС -ийн доктор, дэд профессор багш нарыг урьж технологийг хүний эрхийн зөрчил илрүүлэхэд ашиглах нь хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчид хорих газрын олон улсын стандарт, аюулгүй байдал, нийгмийн ажлын талаар сонирхсон асуултаа асууж, хэлэлцүүлэг өрнүүллээ.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ КИНОГООР ОЛГОЖ БАЙНА.

Нээлттэй Нийгэм Форумтай хамтран иргэдийг соён гэгээрүүлэх,хүний эрхийн мэдлэгийг нь нэмэгдүүлэх чиглэлээр их дэлгүүрийн ICINEMA-д кино хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Оролцогчид хүний наймаа, охид эмэгтэйчүүдийн эрх, шударга бус шүүх ажиллагаа, компаний хариуцлагагүй байдлын улмаас хүний эрх зөрчигдөж байгаа асуудлаар үзэл бодлоо илэрхийлж, санал солилцлоо.



ТА ДЭЛХИЙ ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН

Эмнести Интернэшнлийн жил бүрийн Дэлхий дахины хүний эрхийн нөхцөл байдал танилцуулах хэвлэлийн бага хурлыг 2-р сарын 22-нд зохион байгуулж, мэдээ, мэдээлэл, видеог өдөр тутмын сонин, телевиз, цахим сайт, сошиал сулжээгээр олон нийтэд түгээв.

ЯМАЙКА УЛС

Та шударга ёсны төлөө тэмцсэн

Ямайкад цагдаа нар нас залуу, ядуу эрчүүдийг хороох явдал элбэг ба сүүлийн 10 жилд 2000 хүн хороосон байна. Шакела Жексон зэрэг хохирогчдын гэр бүлийнхэн нэгдэж энэ байдлын эсрэг тэмцсэний төлөө айлган сүрдүүлэлтэд өртсөн юм.
Ямайкын ерөнхий сайдад хандан Шакелаг хамгаалж, цагдаа нарын гарт амиа алдсан хүмүүсийн төлөө шударга ёсыг баталгаажуулахыг шаардсан захидал уриалгад иргэд олон нийт гарын үсэгээ зурж нэгдсэн.

ТУРК УЛС

Та тэмцсэний үр дүнд тэд суллагдлаа.

Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа улмаас хилс хэргээр хоригдсон Туркийн Эмнести Интернэшнлийн дарга, захирал бусад хүний эрхийн идэвхтнүүдийг суллахыг уриалж, МЭИ-ийн гишүүд дэмжигчид гарын үсэг цуглуулж илгээсэн.

ГОНДУРАС УЛС

Та бусдыг өмгөөлж үгээ хэлсэн.

Гондурас улсад амдардаг, нутгийн Ленка уугуул хүмүүсийн газар нутгийг уул уурхай, усан цахилгаан станц зэрэг бизнесийн төслүүд сүйрүүлж байгааг эсэргүүцсэн уугуул иргэдийн хөдөлгөөний хүмүүсийг сүрдүүлж, биед нь халдсаар байна.

Гондурасын ерөнхийлөгчид хандаж эрх нь зөрчигдөөд байгаа хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалахийг уриалж эрхийнхээ төлөө бичцгээе арга хэмжээний үеэр захидал гарын үсэг цуглуулсан.

ЧАД УЛС

Та үнэний төлөө үгээ хэлсэн.

Чад улсын хүний эрхийн хамгаалагч Махадин Засгийн газрыг шүүмжилсэн бичлэг фэйсбүүкт байршуулснаасаа болж бүх насаар хорих ялаар шийтгэгдээд байна. Монголын Эмнестигийн гишүүд дэмжигчид Чад улсын ерөнхийлөгчид хандан Махадиныг нэн даруй суллахыг шаардсан захидлууд илгээсэн.

ТА ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ-2017 ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ ЭРСДЭЛД БУЙ ХҮМҮҮСИЙГ СУЛЛУУЛАХЫН ТӨЛӨӨ ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН.

Бангладеш, Чад, Турк, Израйль, Ямайка, Хятад, Гондурас, Мадагаскар улсын хэргүүд дээр ажиллаж, хөдөө орон нутагт Хэнтий, Архангай, Дархан, Эрдэнэт, Хөвсгөл, Завхан аймагт гарын үсэг цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулаа

Улаанбаатар хотод ЕБ-ын 118, 107, 102,Монгени, Шинэ Монгол сургуулиуд, МУИС-ийн ХЗС, ОУХНУС, Отгонтэнгэр,Их засаг, МУБИС, Сүхбаатарын талбайд гарын үсэг цуглуулах үйл ажиллагаа зохион байгуулж 27 000 орчим гарын үсэг цуглуулж илгээлээ.

Мөн www.amnesty.mn сайт болон фэсбүүк хуудсаараа 68 000 орчим хүнд мэдээлэл хүргэв.



ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.



ХЯТАД УЛС

Таны захидал бусдад урам хайрласан.

Ни Юлан 2008 оны Бээжингийн олимпоос болж орон гэргүй болсон олон хүний төлөө дуу хоолойгоо өргөсөн. Түүнийг олон удаа баривчилж, зодож гэмтээсний улмаас тэргэнцэр дээр суудаг болсон. 2017 оны 4-р сард түүний нөхөр хүүхдийг гэрээс нь гаргаж, түүний түрээслэж байсан байрыг нураажээ.

Ни Юланы дэмжиж гарын үсэг зурах, эв санаагаа илэрхийлэх арга хэмжээнд олон хүн нэгдсэн юм.

ТАЙВАН УЛС

Та ЛГБТК хүмүүсийн эрхийн төлөө үгээ хэлсэн.

Тайвань улсын хууль тогтоогч нараас ЛГБТИ хүмүүсийн эрхийг баталгаажуулсан хууль эрх зүйн орчин бий болгоход анхаарал хандуулахыг шаардсан Ази Номхон далайн бүсийн Яаралтай үйл ажиллагаанд Сэтгүүлч, Багш, Хуульч, Эмч бүлгийнхэн нэгдэж, сошиал мэдиагаар сурталчилав.

МЬЯНМАР УЛС

Та дүрвэгсэдэд тусалсан.

Мьянмар улсад сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь зөрчигдөж, хүчирхийлэл аллагад өртөөд байгаа болон энэ аймшигт нөхцөл байдлаас дүрвэсэн Рохинжа нарыг хамгаалахыг уриалж буй Яаралтай үйл ажиллагаанд Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд нэгдэн онлайн үйл ажиллагаа өрнүүллээ. Мөн Бээжинд суугаа Мьянмарын элчин сайдын яаманд хандан албан бичиг хүргүүлэв.

ФИЛИППИН УЛС

Та цаазаар авах ялын эсрэг дуугаа өргөсөн.

Филиппиний эрх баригчдаас хар тамхитай тэмцэх нэрийн дор аллага үйлдэхээ зогсоохыг шаардсан Ази Номхон далайн бүсийн яаралтай үйл ажиллагаанд Монголын Эмнести Интернэшнлийн Оюутны бүлгийн гишүүд нэгдлээ.

КАМБОЖИЙН ВАНТ УЛС

Та хүний эрхийн хамгаалагчийн төлөө захидал уриалгад нэгдсэн.

Камбож улсын ерөнхий сайдад хандан орон байртай байх эрхийн төлөө тайван замаар тэмцэгч, хүний эрхийн хамгаалагч Теп Ванниг суллахыг шаардсан захидал уриалгад гарын үсэг цуглуулж илгээлээ

ТА ХОНГКОНГ, ВЬЕТНАМЫН ЗАЛУУ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДАД ХАНДАН ЭВ НЭГДЭЛЭЭ ИЛЭРХИЙЛЛЭЭ.

МЭИ-ээс Хонконгийн эрх баригч нарт хандан тайван замаар жагсагчдыг яллахаа зогсоохыг шаардсан албан захидал явуулаа.

Эмнести Интернэшнлийн залуучууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсний төлөө хоригдож буй Жошуа болон түүний нөхдөд хандан эв санааны нэгдлээ илэрхийлсэн захидлууд илгээсэн.

Хүрээлэн буй орчны бохирдлын асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлснийхээ төлөө хоригдоод байгаа блог хөтлөгч, залуу хүний эрхийн хамгаалагч Ван Хаоугийн төлөө #YoungHRD цахим үйл ажиллагаанд нэгдлээ.

Эмнести Интернэшнлийн Зүүн Ази хариуцсан захирал Николас Бекүйлин МУИС-ийн ОУХНУС дээр "Хятад ба хүний эрх" сэдвээр лекц уншиж, оролцогчид Хятад улс дахь цаазаар авах ял, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, цахим орчны хязгаарлалтын талаар санал болдоо хуваалцлаа.





ТА ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ ТАЙВНААР ЖАГССАН

Хүний эрхийн ТББ-уудын форумаас зохион байгуулсан "Хэнийг ч орхилгүй хөгжье" нэгдсэн цуглааны үеэр Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд, сайн дурынханы бүтээсэн ээлтэй хот бэлгийн хайрцгийг "Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх" онол, практикийн багa хурлын зөвлөмжийн хамт УИХ-ын дарга М.Энхболд, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Барилга хот байгуулалтын Х.Баделхан болон Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт хүргэж өглөө.

Мөн гэр хороолол, хот дахин төлөвлөлтийн бодлогоо эргэн харах, албадан нүүлгэх, орон гэргүй үлдэхээс хамгаалсан хуулийн хамгаалалтыг бий болгохыг сануулсан "Олон улсын хүний эрхийн өдрийн мэндчилгээ"-г УИХ-ын гишүүд НИТХ-ын тэргүүлэгчид болон төлөөлөгчид, дүүргүүдийн газрын албадын дарга нар зэрэг 119 эрх бүхий албан тушаалтнуудад илгээсэн.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ нөлөөллийн ажил

"Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх" онол, практикийн багa хурлыг Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Хуульчдын Холбоо, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран зохион байгуулсан.

Төр, төсөл хэрэгжүүлэгч компани болон дахин төлөвлөлтөд өртсөн иргэдийн төлөөлөл хот дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар мэдээлэл өгч, эрдэмтэн, багш, судлаач, хуульч, өмгөөлөгчид хүний эрхэд суурилсан хандлагаар шүүн хэлэлцлээ.

Хурлаас гарсан зөвлөмжийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон төлөөлөгчид, Барилга, хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, нийслэлийн дүүргүүдийн газрын алба, УИХ-ын Хүний эрхийн Дэд хороо зэрэг холбогдох сайд, дарга, албан тушаалтанд хүргүүлсэн.

Илтгэлийн эмтхгэлийг хэвлэн, хамтрагчид, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага болон дахин төлөвлөлтөд өртсөн иргэдийн хүртээл болгоод байна.







ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ТА ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧ БОЛСОН.

Гэр хорооллын дахин төлөвлөлт болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган дахин барих төсөлд хамрагдсан иргэдийн "Эрхээ хэрхэн хамгаалах вэ?" туршлага солилцох уулзалт, сургалтыг 3 удаа зохион байгуулж 6 газрын 134 хүнийг хамарсан. Эдгээр иргэдийн дундаас 2 төрийн бус байгууллага шинээр бий болж орон байртай байх эрхийнхээ төлөө тэмцдэг идэвтхнүүд болоод байна.

МЭИ-ийг Хуульчдын бүлэг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох тухай журмын төсөлд санал өгч, саналыг БХБЯ-нд хүргүүлсэн.



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ

ЮНЕСКО, Глоб Интернэшнл ТББ-уудаас зохион байгуулсан "Олон улсын мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөрийн сонсгол" арга хэмжээнд оролцож хүний эрхийг дээдэлсэн, тогтвортой хөгжлийг дэмжсэн хот төлөвлөлтийн талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

Мөн НҮБ-ын ЭЗНСЭ хорооны орон байртай байх эрхийн тусгай илтгэгчийн хүсэлтийн дагуу "Хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь "судалгааны зөвлөмжийг илгээсэн.



ТА ТЭМЦСНИЙ ҮР ДҮНД ТЭД АНХААРАЛДАА АВСАН

УИХ-ын гишүүд, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчид болон холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлагт "Хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь" орон байртай байх эрхийн судалгааны тайланг хүргүүлснээр зарим тэдний зарим нэг нь анхаарч ажиллана гэсэн хариу албан бичиг ирүүлсэн бол УИХ-ын даргын ЭЗНС-ын асуудал хариуцсан зөвлөхөөс ирж уулзан уг асуудлыг судалж, анхаарч ажиллана гэв.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн кампанит ажлын мэдээ, мэдээллийг гишүүд, дэмжигчид тэр дундаа хуульч, багш, оюутан, сурагчдын бүлгийн гишүүд, иргэний нийгмийн байгууллагууд, холбогдох төрийн албан хаагчдад сургалт, хэлэлцүүлэг, кино хэлэлцүүлэг, өглөөний уулзалт зэрэг олон хэлбэрээр хүргэж ажилласны үр дүнд гишүүд үгээ хэлдэг, үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог боллоо.







ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ КАМПАНИТ АЖИЛ



ТА МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙГ АВЧ ХЭЛЭЛЦСЭН

Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, бодитоор эдлүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал хувь нэмэртэй. Төр засаг хүний эрхийн боловсролыг албан боловсролын тогтолцоогоор түгээхээс гадна цагдаа, шүүх, захиргааны байгууллага, эмч, эмнэлгийн ажилтан зэрэг төрийн бүх албан хаагч, агентлаг болон хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд хүний эрхийн боловсрол, сургалтаар үргэлжлүүлэн хангах ёстой.

Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөр болон Тунхаглалыг баталсан нь багш, сурган хүмүүжүүлэгч, бодлого боловсруулагч--дад үндэсний бодлого, тэргүүлэх зорилтуудаа олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн дахин нягтлах боломж олголоо.

Монголын Эмнести Интернэшнл, ХЭҮК, Монголын Хуульчдын Холбоо, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран эрдэмтэн багш, судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтэн, албан хаагчдын дунд "Монгол улс дахь хүний эрхийн боловсролын өнгөрсөн, одоо, ирээдүй" онол, практикийн багa хурлыг зохион байгуулж, БСШУС-ын сайд, ХЭҮК-ийн дарга, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч зэрэг төрийн болон төрийн бус байгууллага,эрдэмтэн, судлаач, багш зэрэг 90 орчим хүн оролцов.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ-2017 ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛ

Хурлаар хүний эрхийн боловсролын асуудалд бүх нийтийн анхаарлыг хандуулж, Монгол улсад Дэлхийн хүний эрхийн боловсролын НҮБ-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг онол, практикийн түвшинд судлан, цаашид сайжруулах арга замыг санал болгосон зөвлөмж гаргахын зэрэгцээ ХЭТТ-ын 70 жилийн ойг тохиолдуулан олон улсын Хүний эрхийн өдрөөр гурав дахь онол, практикийн багa хурлыг зохион байгуулахаар шийдвэрлэв.

Монголын Эмнести Интернэшнл "Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр" боловсруулахад гар бие оролцон, Багш, Хуульч, Эмэгтэйчүүдийн бүлэг хөтөлбөрийн төсөлд хүний эрхийг хэрхэн уялдуулах, хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлж, санал өгч идэвхижсэн.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ХҮНИЙ ЭРХИЙГ НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ НЭГТГЭСЭН

НҮБ-ын Хүний эрхийн Боловсролын Дэлхийн хөтөлбөрийн "Бага дунд боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролыг нэгтгэх" зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн багш нарын дунд "Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь" нээлттэй хичээлийн уралдааныг зохион байгууллаа.

2017-2018 оны хичээлийн жилд НЗД-ын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн дэмжлэгтэйгээр 118 дугаар сургуулийг түшиглэн ХУД-ийн хэмжээнд зохион байгууллаа.

Уралдаанд нийт 13 мэргэжлийн 26 багш 118 дугаар сургуулийн 2-12 дугаар ангийн 21 бүлгийн сурагчдад ерөнхий эрдмийн хичээлийн агуулгад хүний эрхийг нэгтгэсэн нээлттэй хичээлээ заажөрсөлдөв.







ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ТА ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭДЭГ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ШААРДСАН

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын малчидтай малчны хотонд уулзаж уул уурхайн нөлөөлөл хүний эрхийн асуудлаар ярилцлаа.

Уул уурхайн нөлөөлөл, тэр дундаа нүүрс тээвэрлэгч том оврын авто машинаас үүсдэг тоосжилт үндны ус, малын бэлчээрийг хомсдуулж, хүн малын эрүүл мэндэд нөлөөлж, малаас авах ашиг шимийг бууруулж нүүдлийн соёлд аюул заналхийлэл учруулж байгааг малчид онцолж Хүний эрхийг хүндэлдэг хариуцлагатай уул уурхайг бий болгохын төлөө нэгдэж УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд 920 хүний гарын үсэг бүхий гомдол гаргасан.

Даланжаргалангийн малчдад хүний эрхийн сургалт хийснээр засаг дарга, уул уурхайн компанитай байгуулах 3 талт гэрээний төсөлд санал өгөх эрхтэй болоод байна.

ТА ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛЫГ ФИЛОСОФИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗСЭН.

ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Эмнести Интернэшнл, ШУТИС-ийн БУХС, МУИС-ийн Философи, Шашин судлалын тэнхим хамтран "Философи-хүний эрхийн уулзварт" Философийн улсын VIII, IX олимпиадыг зохион байгууллаа.

Философийн улсын IX олимпиадыг "Цахим эрх чөлөө" сэдвээр зохион байгуулснаар цахим эрх, цахим аюулгүй байдал зэрэг өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудалд философийн үүднээс үүднээс эргэцүүлэн тунгаах, илтгэх, дүгнэхэд суралцсан байна.

Түүнчлэн, "Хиймэл оюун ба хүний эрх", "Цахим эрх чөлөө ба боломж" болон "Био этик" зэрэг сэдвээр гишүүд, олон нийтэд хэлэлцүүлэг өрнүүлсэн нь хүний эрх, философийн талаарх ойлголт, уялдааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ сонирхогчдын хүрээг тэлсэн үр нөлөөтэй байна.







ТА ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЛЭГЭЭРЭЭ МЭТГЭЛЦСЭН.

ЕБС-ийн сургуулиудын багш нарт зориулсан "Хүний эрхэд суурилсан мэтгэлцээн" сургалтын агуулга гаргалаа.

"Эрхээ мэдье" –ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын мэтгэлцээний тэмцээнийг Отгонтэнгэр их сургууль, Монголын мэтгэлцээний нэгдсэн тэнхим, Карл Попперын мэтгэлцээний нийгэмлэг хамтран нийт 15 шүүгч, 20 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж 114 багийн 342 сурагч хүний эрхийн мэдлэгээрээ мэтгэлцлээ.

Шоглох, дарамтлах, гадуурхахын эсрэг ЕБС-ийн сургуулийн сурагчид, өсвөр насны хүүхдүүдэд зориулсан "Тэнцэтгэлийг өөрчилье" сургалтын модуль боловсруулж, Галакси хүүхдийн зуслангийн 100 гаруй амрагч хүүхдэд туршиж, сургалт явуулах залуу сургагч багш нарыг бэлтгэлээ. ХЭЭС хөтөлбөрт хамрагдсан 5 сургуулийн 340 сурагчдад хүрлээ.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ ХӨТӨЛБӨР

Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургуулиудыг дэмжих ажлын хүрээнд "Манай сургууль хүний эрхэд ээлтэй сургууль" гэрэл зургийн уралдаан, "Миний мөрөөдлийн сургууль" төслийн тэтгэлэгт уралдааныг тус тус зарлаж, Монгени цогцолбор сургууль, Шинэ эхлэл сургууль болон 107 дугаар сургуулуид шалгаран тэтгэлгийн эзэд боллоо.

Орхон аймгийн БСГаймгийн ЕБС-иудад "Хүний эрхэд ээлтэй сургууль" хөтөлбөрийн үзэл санаа, зарчмыг тугээн дэлгэрүүлэххүрээнд хамтран ажиллахаар Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

Эрдэнэт хотын ХЭЭС-иудын чадавхийг бэхжүүлэх сургалт, туршлага судлах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулснаар 5, 2 дугаар сургууль хөтөлбөрт хамрагдах саналаа ирүүлжээ.









ТА ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ИЛҮҮ ИХ ҮР НӨЛӨӨНД ХҮРЧ ЧАДАХ, ИЛҮҮ ТОМ, ИЛҮҮ ХҮЧТЭЙ, ИЛҮҮ ОЛОН ТАЛТ ХӨДӨЛГӨӨН БОЛГОХЫН ТӨЛӨӨ АЖИЛЛАА.

Шинэ гишүүдийн сургалт, кампанит ажлын сургалт, бүх гишүүдийн улирал тутмын уулзалт, хүний эрхийн асуудлаарх лекц, илтгэл, чөлөөт ярилцлага зэрэг гишүүдэд чиглэсэн 144 үйл ажиллагаанд давтагдсан тоогоор нийт 8570 гаруй гишүүд, дэмжигчид оролцлоо.

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН XIX ЧУУЛГАН

Монголын Эмнести Интернэшнлийн XIX чуулган 6-р сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж, Олон Улсын Зөвлөлийн хурлаар хэлэлцэх шийдэврүүдэд баримтлах байр суурь, саналыг батлаж, 2017-2020 оны нэн тэргүүнд анхаарч ажиллах стратегийн чиглэлийг тодорхойлж, дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн,Удирдах зөвлөл, Хяналтын Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг сонгон батламжилав.



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНЕРНЭШНЛ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Шинээр сонгогдсон Удирдах Зөвлөл Хяналтын Зөвлөлийн гишүүд, Бүлгийн ахлагч нар болон ажилтнууд “Манлайлал”-ын сургалтанд хамрагдлаа.

Удирдах зөвлөл нийт 7 удаа хуралдаж, 24 шийдвэр гаргаснаас 2 шийдвэр хэрэгжих шатандаа, бусад нь биелсэн. Хяналтын зөвлөл 6 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна.



ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХҮРСЭН ГАЗРУУД



Олон нийтийн арга хэмжээ

Эрхээ мэдье мэтгэлцээн

Сургалт, уулзалт

ТА НИЙГМИЙН СҮЛЖЭЭГЭЭР ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛСЭД ОРОЛЦСОН

цахим хуудсаар 624631 хүнд мэдээлэл хүргэсэн

27596 хариу үйлдэл үзүүлсэн

1667 хүн шинээр дагасан

500 орчим цахим гарын үсэг илгээсэн.

ТА МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛД ШИНЭ ГИШҮҮН БОЛЛОО.

Шинэ гишүүдийн сургалт, кампанит ажлын сургалт, бүх гишүүдийн улирал тутмын уулзалт, хүний эрхийн асуудлаарх лекц, илтгэл, чөлөөт ярилцлага зэрэг гишүүдэд чиглэсэн 144 үйл ажиллагаанд давтагдсан тоогоор нийт 8570 гаруй гишүүд, дэмжигчид оролцлоо.

"Sweet September for Human Rights" аян болон бусад кампанит ажлын үеэр МЭИ-д 740 гаруй шинэ гишүүн элсэв.



ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БҮХ ГИШҮҮДИЙН УУЛЗАЛТ

Бүх гишүүдийн уулзалтыг 3 удаа хийж, давхардсан тоогоор 250 гаруй гишүүд оролцож цаазаар авах ялыг халах, хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд оруулсан гишүүддээ талархалаа илэрхийлж, шилдгүүдээ тодрууллаа.



ТА ХҮН БҮРТ ХҮНИЙ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ АЖИЛЛАЖ БАЙНА.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

ОРЛОГО 2017		2017 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31 Төсөв (ам. доллар)	2017 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31 Гүйцэтгэл (ам. доллар)
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт		6,450	1,017.08
Тогтмол бус хандив		3,000	447.78
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт		21,400	4,929.56
Томоохон хандивлагчдын хандив		18,750	3,621.79
Бусад сан арвижуулалтын орлого		7,900	6,004.18
Гаднаас олсон нийт орлогын дүн		**57,500**	**16,020.39**
ОУТөвийн санхүүжилт		**170,179**	**216,878.64**
НИЙТ САНХҮҮЖИЛТ		**227,679**	**232,899.03**
ЗАРЛАГА 2017			
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 4	98,050	65,009.51
Өсөлтийн стратегийн зорилт	Зорилго 5 - Сан арвижуулах	22,950	13,039.59
Зорилго 5	Зорилго 5- Бусад асуудал	27,341	20,864.77
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		8,056	5,983.38
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны		71,283	53,967.49
НИЙТ ЗАРДАЛ		**227,679**	**158,864.74**
	Эхний үлдэгдэл		
	Бэлэн мөнгө [касс ба банк]	24,799.74	
	Нөөц сан	38,814.70	
	Урьдчилж төлсөн төлбөр	55.59	
	Авлага	856.89	
	Өглөг	7,861.60	
	Эцсийн үлдэгдэл		
	Бэлэн мөнгө [касс ба банк]		104,982.01
	Нөөц сан		40,095.50
	Урьдчилж төлсөн төлбөр		80.67
	Авлага		1,141.68
	Өглөг		15,600.25

Тайланг боловсруулсан ня-бо: Т.Ариунаа

Хянасан гүйцэтгэх захирал Б.Алтантуяа